



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 5/26

Улаанбаатар хот

Ёс зүйн байнгын хороог байгуулах тухай

Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм", Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын Ёс зүйн хороог олонхийн саналыг үндэслэн дэд дарга Х.Галымбек, ахлах мэргэжилтэн М.Амарбаяр, мэргэжилтэн Д.Санчирбаяр нарын гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж даргаар нь М.Амарбаярыг томилон ажиллуулсугай.

2. Албаны үйл ажиллагаанд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг мөрдлөг болгон ажиллахыг ёс зүйн хороо /М.Амарбаяр/-нд үүрэг болгосугай.

3. Албаны дэргэд Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий ёс зүйн байнгын хороог байгуулан ажиллаж буйтай холбоотойгоор нийт албан хаагчдад энэ талаар гарсан хууль тогтоомжийг судлан, мөрдлөгө болгон ажиллахыг даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН